



НИЙСЛЭЛИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2016 оны 06 сарын 27 өдөр

Дугаар А/39

Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Биеийн тамир, спортын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.6, 18.7, 18.10 дахь заалт, 20 дугаар зүйлийн 20.3 дахь заалт, 2015 оны А/118 дугаар захирамжаар батлагдсан “Оюутны болон өсвөрийн шигшээ багийн ажиллах журам, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” журмын 4 дүгээр зүйлийн 4.1, 4.3 дугаар заалт, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2013 – 2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр, нийслэлийн эдийн засаг нийгмийн 2016 оны зорилтыг тус тус хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Нийслэлийн Засаг даргын дэргэдэх оюутны шигшээ багийн жүдо бөхийн тамирчин Д.Сумьяа, Ц.Наранжаргал, М.Ууганжаргал, Д.Төмөрхүлэг, Л.Отгонбаатар нарыг Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотноо зохион байгуулагдах Олон улсын Жүдо бөхийн холбооны дэлхийн чансааны оноо олгох “Чингис Хаан Гран при Улаанбаатар 2016” жүдо бөхийн тэмцээн болон “Рио 2016” Олимпын их наадамд оролцохоор 2016 оны 06 дугаар сарын 20-ноос 07 дугаар сарын 28-ны хооронд бэлтгэл, сургуулилтыг хангахад нь зориулж, бэлтгэл цугларалт, витаминжуулалтын зардал гаргахыг зөвшөөрсүгэй.

2. Тамирчдын бэлтгэл цугларалт, витаминжуулалтын зардалд шаардагдах төсвийг хавсралтаар баталсугай.

3. Тамирчдын бэлтгэл цугларалт, витаминжуулалтын зардалд шаардагдах 5.000.000 /таван сая/ төгрөгийг Оюутны шигшээ багийн зардлаас гаргахыг нягтлан бодогч /О.Эрдэнэцэцэг/-д зөвшөөрсүгэй.

4. Тамирчдын бэлтгэл цугларалт, витаминжуулалтын зардлын тооцоог 2016 оны 07 дугаар сард багтаан дуусгахыг шигшээ багийн ахлах дасгалжуулагч Ө.Рагчаадоржид үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБОЛД

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын даргын
2016 оны Зурав сарын 27 ны өдрийн
А.УС тоот тушаалын хавсралт



Тамирчдын бэлтгэл цугларалт,
витаминжуулалтын зардлын төсөв

№	Зардлын нэр	Хүний тоо	Дүн
1.	30 хоногын байр, хоолны зардал	5 тамирчин	4.500.000
2.	Витаминжуулалтын зардал	5 тамирчин	500.000
Дүн			5.000.000

БОЛОВСРУУЛСАН:

A handwritten signature in blue ink, appearing to be "А.Болдмаа".

А.БОЛДМАА

ХЯНАСАН:

О.ЭРДЭНЭЦЭЦЭГ